



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/21

Мандалговь

┌ Эд хөрөнгийн тооллого хийх тооллогын ┐  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 37.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь заалтууд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 72 дугаар зүйлийн 72.1, 72.4, 72.5 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эд хөрөнгийн 2024 оны хагас жилийн дотоодын тооллогыг 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсүгэй.

2. Эд хөрөнгийн 2024 оны хагас жилийн дотоодын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга Ш.Мөнгөнцэцэг (Захиргаа, хуулийн тасгийн дарга)

Гишүүдэд Ч.Оюунжаргал (Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга)

Н.Мөнгөнтуяа (Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга)

Н.Долгорсүрэн (Нягтлан бодогч)

Ш.Хэрлэнбямба (Нярав)

3. Эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай хийж өмч хамгаалах зөвлөлд танилцуулахыг комиссын дарга (Ш.Мөнгөнцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.ТУЯАЦЭЦЭГ